



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**Даланзадгад
2022 он**

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1. Бодлогын зорилтыг хангах талаар

- 1.1. Удирдлага зохион байгуулалт
- 1.2. Мэдээлэл, сургалт
- 1.3. Цаг үеийн ажил
- 1.4. Аймаг, орон нутгийн удирдлагатай хамтран ажиллаж, хэрэгжүүлж буй ажил
- 1.5. Боловсон хүчний талаар
- 1.6. Тайлан мэдээ, албан бичиг
- 1.7. Тайлан мэдээ, албан бичгийн талаар
- 1.8. Санхүү, үнэт цаасны тооцоо, тайлан мэдээ

2. Иргэний улсын бүртгэл

- 2.1. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл, шилжилт хөдөлгөөний бүртгэл
- 2.2. Гадаадад зорчих эрхийн бүртгэл
- 2.3. Иргэний үнэмлэх олгох ажил
- 2.4. Иргэний бүртгэлийн архивийн лавлагаа, тайлан мэдээ

3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл

- 3.1. Иргэн, хуулийн этгээдийн өмчлөх эрхийн баталгаажуулалт, өөрчлөлт, түүнтэй холбоотой бусад эрхийн бүртгэл, лавлагаа, тайлан мэдээ
- 3.2. Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн бүртгэл
- 3.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх мэдээллийн сан, нотлох баримтаар хувийн хэрэг бүрдүүлж, иргэн, хуулийн этгээд болон хууль хяналтын байгууллагыг лавлагаа, мэдээллээр хангах чиглэлээр

4. Хуулийн этгээдийн улсын бүртгэл

- 4.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэл, лавлагаа, тайлан мэдээ

5. Програм хангамжийн талаар

6. Улсын бүртгэлийн хяналт, шалгалт

- 6.1 Хяналт шалгалт - Иргэний бүртгэлийн чиглэлээр
- 6.2 Хяналт шалгалт - Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр
- 6.3 Хяналт шалгалт - Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр
- 6.4 Бусад ажил үйлчилгээ

7. Удирдлагын багт тавих санал

БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР

1.1 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГазрын даргын 2018 оны 07 дугаар сарын 20 ны өдрийн Б/07 тоот тушаалаар батлагдсан орон тооны дагуу 2022 онд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 2, иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 2, хуулийн этгээдийн улсын бүртгэгч 1, архивч 2, ахлах нягтлан бодогч 1, нярав, мэдээллийн технологийн ажилтан 1, Архив, бичиг хэргийн ажилтан 1, гэрээт албан хаагч үйлчлэгч 2, жижүүр 2, 14 сумын 12 улсын бүртгэгч, нийт 29 албан хаагчтайгаар Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон орон нутгийн удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар, удирдамж чиглэл, тушаал, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч бүртгэлийг хөтлөн хэрэгжилтийг өдөр тутмын ажил, үйлчилгээнд бүрэн хэрэгжүүлж, иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг орон нутагт эрхлэн зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн Улсын бүртгэлийн үйлчилгээг үнэн зөв, ил тод, түргэн шуурхай, шударга, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэн ажиллаж байна.

1.2 МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ.

➤ 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Төрийн албаны салбар зөвлөлөөс “Аз жаргалтай ажиллахын нууц” сэдэвт онлайн сургалтад нийт 16 албан хаагч хамрагдсан.

➤ 2022 оны 01 дүгээр сарын 19нд Өмнөговь аймгийн прокурорын газраас зохион байгуулсан цахим уулзалтад Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг нар оролцов.

➤ 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр УБЕГ-аас “Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтныг мэргэшүүлэх” арга зүйн онлайн сургалтанд ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Ариунсайхан, Д.Наранбилэг нар оролцсон.

➤ 2022 оны 01 дүгээр 20-ны өдөр Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Улсын их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн үзэл баримтлал, зохицуулах харилцаа”-ны тухай сургалтад хэлтсийн 13 албан хаагч хамрагдсан.

➤ 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Орчин үеийн хөгжлийн мегатрэндүүд” сэдэвт онлайн сургалтад хэлтсийн 27 албан хаагчид хамрагдсан.

➤ 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Монгол орны хөгжлийн хэтийн төлөв” сэдэвт онлайн сургалтад хэлтсийн 24 албан хаагч хамрагдсан.

➤ 2022 оны 02 дугаар 17-ны өдөр Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Коронавируст хадлдар тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам” сэдэвт онлайн сургалтад хэлтсийн 24 албан хаагч хамрагдсан.

➤ 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр И-Монгол академи УТҮГ-ын Цахим ур чадвар хөгжүүлэлтийн алба “Төрийн албан хаагчдын мэдээллийн технологи ашиглах чадавхыг хөгжүүлэх” сэдэвт цахим онлайн сургалтанд Мэдээллийн технологийн ажилтан О.Эрдэнэбат оролцсон.

➤ 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Монгол улсын Сангийн яамны Төрийн сангийн газраас “Цахим гүйлгээ нэвтрүүлэх” сэдэвт танхимын сургалтанд Ахлах нягтлан бодогч С.Батхүү оролцсон.

➤ 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Алдаа дутагдлыг шийдвэрлэх нь” сэдэвт онлайн сургалтад хэлтсийн 19 албан хаагч хамрагдсан.

➤ 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан онлайн сургалтад хэлтсийн 14 албан хаагч хамрагдсан.

➤ 2022 оны 04 дүгээр сарын 01-22-ны өдрүүдэд УБЕГ-аас “Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх” сэдэвт сургалтанд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Мэдээллийн технологийн ажилтан О.Эрдэнэбат, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Ариунсайхан нар хамрагдсан.

➤ 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан онлайн сургалтад хэлтсийн 17 албан хаагч хамрагдсан.

➤ 2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх “Албан тушаалын дамжаа” сэдэвт сургалтанд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх хамрагдсан.

➤ 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан онлайн сургалтад хэлтсийн 17 албан хаагч хамрагдсан.

➤ 2022 оны 04 дүгээр сарын 14-15-ны өдөр УБЕГ-с “Сургагч багш бэлтгэх” сэдэвт танхимын сургалтанд Мэдээллийн технологийн ажилтан О.Эрдэнэбат, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Ариунсайхан нар оролцсон.

➤ 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр УБЕГ-ын “Улсын бүртгэлийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн”-д Хэлтсийн дарга Ч.Энхмөнх оролцсон.

➤ 2022 оны 05 дугаар сарын 05-ний өдөр Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан онлайн сургалтад хэлтсийн 16 албан хаагч хамрагдсан.

➤ 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдөр УБЕГ-аас “Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл”-ийн ДАТА төвийн нээлтэд Хэлтсийн бүх алба хаагчид оролцсон.

➤ 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр УБЕГ-аас “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх” сэдэвт онлайн сургалтанд хэлтсийн нийт албан хаагчид хамрагдсан.

➤ 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр УБЕГ-аас “Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийг /нөхөн, дахин/

хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулах” сэдэвт онлайн сургалтанд Мэдээллийн технологийн ажилтан О.Эрдэнэбат, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Ариунсайхан нар хамрагдсан.

➤ 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр УБЕГ-с “Эрсдлийн үнэлгээний менежментийн” онлайн сургалтанд Хэлтсийн дарга Ч.Энхмөнх хамрагдсан.

➤ 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр ТАЗ-өөс “Төрийн албаны шинэ сорилтууд” сэдэвт онлайн сургалтад албан хаагчдыг хамруулсан.

➤ 2022 оны 06 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд Аймгийн засаг даргын Тамгын газраас “Багийн оролцоо ба ажлын бүтээмж” сэдэвт танхимын сургалтад Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Архив, Бичиг хэргийн ажилтан О.Жижигчулуун нар хамрагдсан.

➤ 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас “Ажлын байранд бэлтгэх” сэдэвт онлайн сургалтанд 2022 онд шинээр томилогдсон Номгон сумын улсын бүртгэгч М.Уранцэцэг, Сэврэй сумын улсын бүртгэгч С.Мөнхбаяр, Булган сумын улсын бүртгэгч М.Азхүү нар хамрагдсан.

➤ 2022 оны 08 дугаар сарын 16-ны өдөр Өмнөговь аймгийн Онцгой байдлын газраас “Галын аюулгүй байдлын тухай” сэдэвт танхимын сургалтад хэлтсийн нийт албан хаагчид хамрагдсан.

➤ 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Энхийн хүслэн өрхийн эрүүл мэндийн төвөөс “Илүүдэл жин ба эрүүл хооллолт” сэдэвт танхимын сургалтад хэлтсийн нийт албан хаагчид бүрэн хамрагдаж зөвлөгөө мэдээлэл авсан.

➤ 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдөр И-Монголиа академиас “Цахим засаглалын мэдлэг чадварыг дээшлүүлэх” онлайн сургалтад нийт албан хаагчдыг хамруулсан.

➤ 2022 оны 09 дүгээр сарын 01-02-ний өдрүүдэд Улсын бүртгэлийн ерөнхий газраас “E-Doc” программын сургалтад нийт албан хаагчдыг хамруулсан.

➤ 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Өмнөговь аймгийн Насан туршийн боловсролын төвөөс “Харилцаа хандлага” сэдэвт танхимын сургалтад хэлтсийн албан хаагчдыг хамруулсан.

➤ 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Насан туршийн боловсролын төвөөс “Амьдралаа гайхамшиг болгоё” сэдэвт танхимын сургалтад нийт албан хаагчид хамрагдсан.

➤ 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газраас Хяналт шинжилгээний ажилтныг чадавхжуулах сургалтад Архив, Бичиг хэргийн ажилтан О.Жижигчулуун хамрагдсан.

➤ 2022 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас “Гэрэл зургын” онлайн сургалтад Мэдээллийн технологийн ажилтан О.Эрдэнэбат хамрагдсан.

➤ 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас “Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг, маргааны” сургалтанд хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Хяналтын улсын байцаагч Д.Наранбилэг, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Азжаргал, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Ариунсайхан нар хамрагдсан.

➤ 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдөр Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газраас “Агентлагын дарга нарыг чадавхжуулах ” сургалтад хэлтсийн дарга Ч.Энхмөнх хамрагдсан.

➤ 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас “Улсын бүртгэлийн албан хаагчдад зориулсан дотоод” сургалтад Улсын бүртгэлийн хэлтсийн ахлах нягтлан бодогч С.Батхүү хамрагдсан.

➤ 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газраас “Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын шинэчилсэн найруулгын талаарх сургалтад хэлтсийн нийт албан хаагчид хамрагдав.

➤ 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Онцгой байдлын газраас “Гамшгаас хамгаалах менежмент” удирдах бүрэлдэхүүний сургалтад Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Улсын бүртгэлийн хэлтсийн гамшгаас хамгаалах бэлэн байдлы мэргэжлийн ангийн албан хаагчид хамрагдсан.

➤ 2022 оны 11 дүгээр сарын 04-05-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газраас “Цахим Өмнөговь- Чадварлаг төрийн албан хаагч” Сэдэвт сургалтад Хэлтсийн дарга Ч.Энхмөнх, Архив, Бичиг хэргийн ажилтан О.Жижигчулуун, Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч З.Хасар нар хамрагдсан.

➤ 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль” сурталчилан таниулах танхимын сургалтад Архив, Бичиг хэргийн ажилтан О.Жижигчулуун хамрагдсан.

1.3 ЦАГ ҮЕИЙН АЖИЛ

- 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс шинэ дэвшилтэт технологит нийцсэн КИОСК машиныг үйлчилгээнд нэвтрүүлсэн.
- 2022 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Үндсэн хуулийн нэрэмжит Теннисний тэмцээнд Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсүрэн алтан медаль, Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч З.Хасар хүрэл медаль авч амжилттай оролцсон.
- 2022 оны 01 дүгээр сард "Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр"-ийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.1 дагуу ковидоор өвчилсөн 4 албан хаагчид цалинтай чөлөө олгож эмчлүүлсэн, төлөвлөгөөний 3.2 дагуу 6 албан хаагчийг рентиген зураг авахуулсан, төлөвлөгөөний 3.5 дагуу нийт 30 албан хаагчыг коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах хэрэгсэлээр тогтмол хангансан мөн хэлтсийн 16 албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэг, оношилгоо, иж бүрэн шинжилгээнд хамруулж, /ковид-19/-өөс урьдчилан сэргийлэх вакцин, элэгний в, с вирусын эсрэг вакцин хийлгэсэн.
- Улсын бүртгэлийн хэлтсийн ахлах нягтлан бодогч С.Батхүүд Аймгийн Засаг даргаас "Нутгийн дэм" хөтөлбөрийн хүрээнд орон сууцны дэмжлэгт 5 000 000 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.
- 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид хэлтсийн гадна талбайн их цэвэрлэгээ хийж тохижуулсан.
- 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Аймгийн засаг даргаас Улсын бүртгэлийн хэлтэс нь 2021 оны үйл ажиллагаагаараа манлайлан "ТЭРГҮҮНИЙ ХАМТ ОЛОН"-ы батламжаар шагнуулав.
- 2022 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Биеийн тамир спортын газраас зохион байгуулсан "Илүүдэл жингүй эртэч Монгол" аянд нэгдэж бүх албан хаагчид өглөөний 7 цагт хэлтсийн В1 давхрын бялдаржуулах танхимд цуглаж өглөөний дасгал хөдөлгөөн тогтмол хийсэн.
- 2022 оны 03 дугаар сарын 11-нд Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон ирж туршлага солилцсон.
- 2022 оны 03 дугаар сарын 23-нд хэлтсийн web sait, facebook хуудас, холбоо барих утасны дугааруудын мэдээлэлтэй QR шинээр хийсэн.

➤ 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Хэлтсийн нийт албан хаагчид Авлигатай тэмцэх газар болон Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвийн цахим хуудсанд цахимаар нэгдсэн.

➤ 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Даланзадгад сумаас зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т Улсын бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь шийдвэрлэн ажилласан.

➤ 2022 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олонд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийг сурталчилан хэрэгжүүлж сарын аян болон улсын үзлэгт амжилттай оролцсон тул “Өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнуулсан.

➤ 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Аймгийн Улаан загалмайн хорооноор зохион байгуулсан “Байгаа зүйлсээрээ бие биедээ тусалъя” аянд нэгдэж хэрэгжүүлсэн ажил үйлчилгээгээрээ “Тусгай байр”-ын шагнал авсан.

➤ 2022 оны 04 дүгээр сарын 28-29 ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Манлай суманд "Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээ" үзүүлэн үндэсний энгийн гадаад паспортын 30 бүртгэл, дахин олголтын 8 бүртгэл авч 43 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Мөн Улсын бүртгэлийн байгууллагын ажил, үйлчилгээг сурталчилан таниулах зорилгоор Манлай суман үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл болсон 8 багийн дунд волейволын нөхөрсөг тэмцээн, ЕБСургийн ахлах ангийн сурагчдын дунд танин мэдэхүй "АХА" тэмцээнийг тус тус зохион байгуулсан.

➤ 2022 оны 05 сарын 02 ны өдрөөс хөдөөгийн 14 сумд болон Даланзадгад сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага дээр Улсын бүртгэгч нар очиж нийт 3744 иргэнд тоон гарын үсгийн бүртгэл хийсэн.

➤ 2022 оны 05 сард хэлтсийн 2 давхрын 203 тоот өрөөг албан хаагчдын хүүхдүүдэд зориулж "Тоглох, амрах өрөө" болгон бүрэн тохижуулсан.

➤ 2022 оны 05 дугаар сарын 08-ны өдөр “Тэрбум мод” тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд “Даланзадгад сумын үдэлт угталтын хаалга”-ны хойд хэсэгт байгуулсан цэцэрлэгт хүрээлэнд 90 ширхэг суулгац тарив.

➤ 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Улсын бүртгэлийн хэтсээс Хан-Уул дүүргийн улсын бүртгэгч Оюун-Эрдэнэд хандивын аян өрнүүлж 280 000 төгрөг хуримтлуулж хандив тусламж үзүүлсэн.

➤ 2022.05.14-ны өдөр Даланзадгад сумын ЗДТГазраас зохион байгуулсан төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх "Хөдөлгөөнт баг" арга хэмжээнд оролцож Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 75, Хуулийн этгээдийн чиглэлээр 25, Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 241 иргэний материал хүлээн авч шийдвэрлэн 158 иргэнд тоон гарын үсэг олгож ажилласан.

➤ 2022 оны 05 дугаар сарын 16,17, 23,24-ны өдрүүдэд Улсын бүртгэлийн хэлтсийн 18 албан хаагчдыг Улаанбаатар хотруу явах болон ирэх унааны зардлыг байгууллагын ҮЭХороо хариуцаж Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт "Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх багц үзлэг, оношилгоо"-нд бүрэн хамруулсан. Тус үзлэгээр Хэлтсийн жижүүр Д.Баттөр нь элэгний хорт хавдартай онош тогтоогдсон тул байгууллагын нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардалаас 300 000 төгрөгийг дэмжлэг олгосон.

➤ 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдөр УБЕГазрын Мэдээллийн технологийн газрын инженер А.Лхагвасүрэнгийн бага охин Цусны хорт хавдартай гэсэн оношлогдсон тул Улсын бүртгэлийн хэлтсээс хандивын аян өрнүүлж 851 000 төгрөг хуримтлуулж хандив өгсөн.

➤ 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Даланзадгад сум дахь байгууллага аж ахуй нэгжийн дэргэдэх эцэг эхийн зөвлөлийн анхдугаар зөвлөгөөнд Улсын бүртгэлийн хэлтсийн "Хүүхэд, Гэр бүлийг дэмжих зөвлөл"-ийн дарга Д.Наранбилэг, гишүүн М.Оюун-Эрдэнэ нар оролцов.

➤ 2022 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Нийтийн хог цэвэрлэгээнд хамрагдаж аймгийн хойд хэсэг 2*2км талбайн хог цэвэрлэсэн.

➤ 2022.05.25-ны өдөр аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан төрийн үйлчилгээний "Явуулын оффис" арга хэмжээний хүрээнд Цогтцэций сумын багуудын нэгдсэн өдөрлөгт ЭХЭУБ-ын 46 иргэнд, Хуулийн этгээдийн чиглэлээр 11 иргэнд, Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 112 иргэнд тус тус үйлчилсэн.

➤ 2022 оны 06 дугаар сарын 01 буюу "Хүүхдийн баяр"-ын өдөр нийт албан хаагчдийн 53 хүүхэд ҮЭХорооноос гарын бэлэг өгч, аймгийн музейг үнэ төлбөргүй үзүүлсэн.

➤ Улсын бүртгэлийн хэлтсийн 2 давхарын 203 тоот өрөөг албан хаагчдын "Хүүхдэд зориулсан өрөө"-г хамт олны нөөц бололцоогоор тохижуулж, албан хаагчидын 1 дүгээр ангийн 6 хүүхэд болон 2-6 дугаар ангийн 7 хүүхэд хичээл, даалгавараа хийх, тоглох боломжийг бүрдүүлсэн.

➤ 2022 оны 10 дугаар сард өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж шугам сүлжээг Гүний ус ХХК-аар шалгуулж мөн хэлтсийн цонхнуудыг дулаалж, их цэвэрлэгээний ажил хийгдсэн.

➤ 2022 оны 11 сард албан хаагчдын эрүүл мэндэд анхаарч Бүгд найрамдах Солонгос улсад үйлдвэрлэгдсэн 4 шатлалт Magic “Ус цэвэршүүлэх төхөөрөмж” хэлтсийн 2 давхарт байршуулсан.

1.4 АЙМАГ, ОРОН НУТГИЙН УДИРДЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ, ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖИЛ:

- 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс КИОСК машиныг үйлчилгээнд нэвтрүүлсэн.

- Албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн ахлах нягтлан бодогч С.Батхүүд Аймгийн засаг даргаас "Нутгийн дэм" хөтөлбөрийн хүрээнд орон сууцны дэмжлэгт 5 000 000 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

- 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Даланзадгад сумаас зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т Улсын бүртгэлийн үйлчилгээг 160 иргэнд үзүүлсэн.

- 2022 оны 04 дүгээр сарын 28-29 ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Манлай суманд "Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээ" үзүүлэн үндэсний энгийн гадаад паспортын 30 бүртгэл, дахин олголтын 8 бүртгэл авч 43 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Мөн Улсын бүртгэлийн байгууллагын ажил, үйлчилгээг сурталчилан таниулах зорилгоор Манлай суманд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл болсон 8 багийн дунд волейволын нөхөрсөг тэмцээн, ЕБСургийн ахлах ангийн сурагчдын дунд танин мэдэхүй "АХА" тэмцээнийг тус тус зохион байгуулсан.

- 2022 оны 05 сарын 02 ны өдрөөс хөдөөгийн 14 сумд болон Даланзадгад сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага дээр Улсын бүртгэгч нар очиж нийт 3744 иргэнд тоон гарын үсгийн бүртгэл хийсэн.

- 2022 оны 05 дугаар сарын 08-ны өдөр “Тэрбум мод” тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд “Даланзадгад сумын үдэлт, угталтын хаалга”-ны хойд хэсэгт байгуулсан цэцэрлэгт хүрээлэнд 90 ширхэг суулгац тарив.

- 2022.05.14-ны өдөр Даланзадгад сумын ЗДТГазраас зохион байгуулсан төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх "Хөдөлгөөнт баг" арга хэмжээнд оролцож Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 75, Хуулийн этгээдийн чиглэлээр 25, Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 241 иргэний материал хүлээн авч шийдвэрлэн 158 иргэнд тоон гарын үсэг олгож ажилласан.

- 2022 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Нийтийн хог цэвэрлэгээнд хамрагдаж Аймгийн хойд хэсэг 2*2км талбайн хог цэвэрлэсэн.

- 2022.05.25-ны өдөр аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан төрийн үйлчилгээний "Явуулын оффис" арга хэмжээний хүрээнд Цогтцэций сумын багуудын нэгдсэн өдөрлөгт ЭХЭУБ-ын 46 иргэнд, Хуулийн этгээдийн чиглэлээр 11 иргэнд, Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 112 иргэнд тус тус үйлчилсэн.

- 2022 оны 06 дугаар сарын 25 ны өдөр аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх "Явуулын оффис" арга хэмжээнд оролцож **60** иргэнд тоон гарын үсэг олгож **135** иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.

- Өмнөговь аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/439 тоот захирамжаар "Орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллого зохион байгуулах" комиссын бүрэлдэхүүнд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Энхмөнх томилогдож хууль журмын дагуу холбогдох ажлыг зохион байгуулан ажилласан.

- 2022 оны 08 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд "Энержи ресурс ХХК, Таван толгой ХХК-ний ажилчдад **58** гадаад паспортын бүртгэл, **580** иргэний тоон гарын үсгийг олгож нийт **646** бүртгэл хийсэн.

- 2022.09.02-03 ны өдөр Ноён суманд нэг цэгийн үйлчилгээ зохион байгуулан нийт **270** иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.

- 2022.09.06-07 ны өдрүүдэд Цогтцэций суманд байрлах "Эрдэнэс таван толгой" ХХК-ний **120** ажилчдад гадаад паспорт, иргэний үнэмлэх, тоон гарын үсэг олгох ажлыг хийж гүйцэтгэсэн.

- 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 03/964 тоот албан бичгээр Өмнөговь аймгийн Засаг дарга Р.Сэддоржид Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлэх санал хүргүүлсэн.

- Монгол улсын Цахим гарын үсгийн тухай хууль, Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Нутгийн хишиг" хөтөлбөрийн 108 дахь

заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын 27-30 ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутаг дэвсгэрт байрлах Цагаан хад сууршлын бүсэд үйл ажиллагаа явуулдаг компаниудын жолооч нарт, “Оюу толгой” ГХОХХК-ний **1657** албан хаагчдад тоон гарын үсэг олгосон.

- Гурвантэс сумын ИТХ-ын 2021.04.23-ны өдрийн 21 тоот тогтоол, 2022.09.28-ны өдрийн А/183 тоот тогтоолуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022.10.10-ны өдрөөс 10.14-ны өдрүүдэд Гурвантэс сумын ЗДТГазартай хамтран улсын бүртгэлийн үйлчилгээгээр **61** иргэнд үйлчилсэн.

- Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “МАК” ХХКомпани, “SGS” ХХКомпаний **315** албан хаагчдад тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулан ажиллаа.

- 2022 оны 10 дугаар сарын 24 ны өдөр 15 сумын Засаг даргын орлогч дарга нар, 59 багийн Засаг дарга нарт Улсын бүртгэлийн хэлтийн дарга Ч.Энхмөнх Улсын бүртгэлийн цахим шилжилт, Тоон гарын үсгийн бүртгэлийн тухай мэдээлэл хийсэн.

- Өмнөговь аймгийн Засаг даргын 2022.11.08-ны өдрийн А/597 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн удирдамжийн дагуу 2022.11.09-ны өдрөөс 11-ны өдрүүдэд Гурвантэс, Ноён сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 11 компани дээр ажиллан үл хөдлөх хөрөнгүүдтэй газар дээр нь танилцаж, ГХБХБ-ын газар, Татварын газартай тулган мэдээлэл солилцож нурааж буулгасан боловч бүртгэлд өөрчлөлт оруулаагүй, хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн, хэмжээ, үнэ зөрүүтэй зэрэг зөрчлийг арилгуулах санал, илтгэх хуудсыг ажлын хэсэгт хүргүүлэн ажилласан.

- Өмнөговь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөр, аймгийн ИТХ-ын 2022 оны 6/1 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засаг даргын 2022.11.08-ны өдрийн А/597 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн удирдамжийн дагуу 2022.11.09-ны өдрөөс 11-ны өдрүүдэд Гурвантэс, Ноён сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 11 компани дээр ажиллан үл хөдлөх хөрөнгүүдтэй газар дээр нь танилцаж, ГХБХБ-ын газар, Татварын газартай тулган мэдээлэл солилцож нурааж буулгасан боловч бүртгэлд өөрчлөлт оруулаагүй, хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн, хэмжээ, үнэ зөрүүтэй зэрэг зөрчлийг арилгуулах санал, илтгэх хуудсыг ажлын хэсэгт хүргүүлэн ажилласан.

- Өмнөговь аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/41663 тоот захирамжаар “Монголын боловсрол-Өнөөдөр” үндэсний нэгдсэн судалгааны ажлын хэсэгт Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ч.Энхмөнх томилогдож хууль журмын дагуу холбогдох ажлыг зохион байгуулан оролцсон.

- Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Хот, хөдөөгийн сэргэлтийн баг”-ийн аймгийн ажлын хэсэгт хэлтсийн дарга Ч.Энхмөнх ажиллаж хууль, журамд өөрчлөлт оруулах тухай саналыг хүргүүлж ажилласан.

- Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 82 жил, “Улсын бүртгэлийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилан таниулах, байгууллага хамт олны хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Даланзадгад сумын 1-8 дугаар багын иргэдэд 2022 оны 11 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулан **370** иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.

- Өмнөговь аймгийн Засаг даргын НУТГИЙН ХИШИГ хөтөлбөрийг хэрэгжүүлэх Залуус хөтөлбөрийн хүрээнд 2022 оны 11 дүгээр сарын 26-ны Улс тунхагласны баярын өдөр 16 нас хүрсэн 250 хүүхэд “Монгол улсын иргэний андгай” өргөж, иргэний үнэмлэхээ гардан авах ажилд Улсын бүртгэлийн хэлтэс хамтран ажилласан

- 2022 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Өмнөговь аймаг Оюу толгой ХХК-тай хамтарсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хэсэг”-т Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Ариунсайхан оролсон.

- Коика олон улсын байгууллагын дэмжлэгээр суурин компьютер 17 ширхэг, дэлгэц 17 ширхэг, зургын аппарат 17 ширхэг, 3 үйлдэлт принтер 17 ширхэг, хурууны хээ уншигч 17 ширхэг, тог баригч 3 ширхэг, скайнер 1 ширхэгийг тус тус шийдвэрлүүлсэн.

1.5 БОЛОВСОН ХҮЧНИЙ ТАЛААР:

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Хэлтсийн дарга 1, Тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, Хяналтын улсын байцаагч 1, Улсын бүртгэгч 12, Ахлах нягтлан бодогч 1, Архивч 2, Нярав, мэдээллийн технологийн ажилтан 1, Архив, бичиг хэргийн ажилтан 1, гэрээт албан хаагч үйлчлэгч 2, жижүүр 2 нийт 29 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Боловсон хүчний талаар гарсан тушаал:

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 18 ны өдрийн Б/33 тоот тушаалаар Даланзадгад сумын улсын бүртгэгч М.Түвшинжаргалыг ажил хавсран гүйцэтгүүлэх тухай,

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 18 ны өдрийн Б/32 тоот тушаалаар Даланзадгад сумын улсын бүртгэгч С.Ариунсайханг ажил хавсран гүйцэтгүүлэх тухай,

➤ Хэлтсийн даргын 2022 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн Б/03 тоот тушаалаар Хэлтсийн үйлчлэгч Х.Чулуунбат, Ц.Насанбаяр нарыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай,

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Б/119 тоот тушаалаар Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Должинсүрэнг ажлаас чөлөөлж Номгон сумын улсын бүртгэгчийн ажилд томилсон тухай,

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн Б/122 тоот тушаалаар Булган сумын улсын бүртгэгчээр М.Азхүүг томилсон тухай,

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн Б/163 тоот тушаалаар Номгон сумын улсын бүртгэгч Б.Должинсүрэнг ажлаас чөлөөлж ажилд томилсон тухай,

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн Б/254 тоот тушаалаар Сэврэй сумын улсын бүртгэгчээр С.Мөнхбаярыг томилсон тухай,

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 53 дугаар сарын 11-ний өдрийн Б/270 тоот тушаалаар Даланзадгад сумын улсын бүртгэгч М.Түвшинжаргалыг ажлаас чөлөөлсөн тухай,

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Б/271 тоот тушаалаар Ханхонгор сумын улсын бүртгэгчээс Б.Баясгаланг ажлаас чөлөөлж Даланзадгад сумын улсын бүртгэгчээр томилсон тухай,

➤ Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Б/286 тоот тушаалаар Баяндалай сумын улсын бүртгэгч Э.Бүрэнзаяаг ажлаас чөлөөлсөн тухай,

➤ Хэлтсийн даргын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Б/06 тоот тушаалаар хэлтсийн жижүүр Д.Баттөрийг үүрэг ажлаас чөлөөлсөн тухай,

- Хэлтсийн даргын 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Б/07 тоот тушаалаар Ү.Болоожийг хэлтсийн жижүүрийн үүрэгт ажилд томилсон тухай,
- Хэлтсийн даргын 2022 оны 07 дугаар сарын 29-ний Б/09 тушаалаар хэлтсийн үйлчлэгч Б.Насантогтохыг ажлаас чөлөөлсөн тухай,
- Хэлтсийн даргын 2022 оны 09 дугаар сарын 14-ний өдрийн Б/10 тоот тушаалаар М.Бүрэнтогтохыг хэлтсийн жижүүрийн үүрэгт ажилд томилсон тухай
- Хэлтсийн даргын 2022 оны 10 дугаар сарын 11-ний Б/11 тоот тушаалаар хэлтсийн жижүүр М.Бүрэнтогтохыг ажлаас чөлөөлсөн тухай,
- Хэлтсийн даргын 2022 оны 10 дугаар сарын 15-ний өдрийн Б/12 тоот тушаалаар С.Өсөхбаярыг хэлтсийн жижүүрийн үүрэгт ажилд томилсон тухай,
- Хэлтсийн даргын 2022 оны 10 дугаар сарын 31-ний Б/13 тоот тушаалаар Мэдээллийн технологийн ажилтан О.Эрдэнэбатыг ажлаас чөлөөлсөн тухай,
- Хэлтсийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Б/15 тоот тушаалаар Ц.Насанбаярыг хэлтсийн үйлчлэгчийн үүрэгт ажилд томилсон тухай,
- Хэлтсийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 02-ний өдрийн Б/16 тоот тушаалаар Х.Хэнмэдэхэвийг хэлтсийн үйлчлэгчийн үүрэгт ажилд томилсон тухай тус тус тушаал гарч, хэрэгжилтийг хангаж ажилласан.

1.6 ТАЙЛАН МЭДЭЭ, АЛБАН БИЧГИЙН ТАЛААР:

2022 онд Улсын бүртгэлийн хэлтэст 923 албан бичиг ирсэнийг зохих журмын дагуу бүртгэн авч холбогдох ажилтнуудад шилжүүлэн, биелэлтэнд хяналт тавьж, 377 хариутай албан бичиг ирснээс хариуг тухай бүрт нь шийдвэрлүүлэн холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн хэлтэст 2022 онд иргэдээс нийт 31 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирсэнээс 31 өргөдлийг шийдвэрлэн холбогдох албан тушаалтан, иргэдэд хариуг хүргүүлэж, өргөдөл гомдол, санал хүсэлтийг холбогдох байгууллагуудад шилжүүлэн шийдвэрлэлтэнд хяналт тавьж, холбогдох газарт цаг тухай бүр хүргүүлэн ажилласан.

1.7 САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. **Төсвийн зарцуулалт:** Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нягтлан бодогч Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг сар бүр холбогдох тодруулгын хамт Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтэст хуулийн хугацаанд нь хүргүүлэн ажилласан.

2022 оны 11 дүгээр сарын байдлаар үйлчилгээний орлогын төлөвлөгөө 192 500 000 /Нэг зуун ерин хоёр сая таван зуун мянган/ төгрөг. Үүнээс 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 200 820 347 /хоёр зуун сая найман зуун хорин мянга гурван зуун дөчин долоон/ төгрөг төвлөрүүлэн ажиллаж байна.

2022 оны 02 дугаар сарын 21 -ний өдөр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Эн Ай Ти эс баланс аудит ХХК-аар шалгуулж “Зөрчилгүй” дүгнэлт авсан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн мэдээг сар бүрийн 8-ны өдрийн дотор 14 үзүүлэлтээр бүрэн гаргаж байршуулан, эхний хагас жилийн тайланг илгээсэн.

2. Үйлчилгээний хураамж, үйл ажиллагааны орлого: 2022 оны 11 дүгээр сарыг 25 ны өдрийн байдлаар Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний хураамж 53 643 807 төгрөгийг 210000089483 тоот дансанд, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний хураамж 109 238 040 төгрөгийг 210000093088 тоот дансанд, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний хураамж 36 454 000 төгрөгийг 210000258471 тоот дансанд тус тус тушаалган Өмнөговь аймгийн Төрийн сангийн 100110012008 тоот дансанд төвлөрүүлэн, сар бүрийн 25-ны дотор Улсын төсөвт төвлөрүүлэн ажиллаж байна.

Бараа материал, үндсэн хөрөнгө: Иргэний бүртгэлийн 21 төрөл, Эд хөрөнгийн бүртгэлийн 3 төрөл, Хуулийн этгээдийн 3 нийт 27 төрлийн үнэт цаас ашиглагдаж байгааг УБЕГазраас хөрөнгийн санхүүжилтээр авч нөөцийг бүрэн ханган ажиллаж байна.

2. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ.

НЭГ. БОДЛОГЫН ЗӨВЛӨГӨӨГӨӨР ХАНГАХ

Тайлангийн хугацаанд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын талаарх тоон мэдээг сар бүр нэгтгэн гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний бүртгэлийн газарт тогтмол хүргүүлэн ажиллаж байна.

Сумдын улсын бүртгэгч нарын сарын мэдээ, тайланг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж байх, улсын бүртгэлийн мэдээллийн санд регистрийн дугаар буруу, овог, нэр, үсгийн зөрүүтэй иргэдийн зөрчлийг тухай бүр арилгаж дуусгах чиглэл өгч ажиллаж байна. Тухайлбал:

- ✓ Иргэний улсын мэдээллийн санд Хяналтын улсын байцаагчийн 11 дүгнэлтээр ИУБ-25, ИУБ-15 маягтыг тус тус нөхөн бичиж мэдээллийн санд оруулсан.
- ✓ Мэдээллийн санд үсгийн алдаатай болон мэдээлэл буруу орсон 164 иргэний мэдээллийн алдааг засуулахаар тухай бүр нь ИУБГазарт албан бичиг, нотлох баримтын хамт хүргүүлж зөрчлийг арилгасан.

Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасаг 2021 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 25 –ны өдрийг хүртлэх хугацаанд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

1. Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2022.01.06-ны өдрийн 4/134 тоот чиглэлийн дагуу жилийн эцсийн байдлаар 15588 бүртгэлийн 26226 хуудас бүрдүүлбэрийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд цахимжуулсан.
2. Тайлант хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 17, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 2, Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан 19, аймаг орон нутгаас зохион байгуулсан 6 сургалтанд цахим болон танхимаар тус тус хамрагдсан.
3. 2021 оны 10 дугаар сарын 11-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртлэх хугацаанд Иргэний улсын бүртгэлийн тасгийн архивт байрлах цаасан суурьт эх нотлох баримтыг Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд, Цахимжуулсан материал харах, ашиглах, засварлах програмд тус тус тулган шалгаж 46890 иргэний хувийн хэргийн 192892 ХААТР маягтыг ангилан ялган галиглаж, бүртгэлжүүлэн стандартын дагуу байрлуулсан.
4. 2022 оны 02 дугаар сард 15 сумын 2021 оны Иргэний улсын бүртгэлийн бүрдүүлбэр материалыг татан авч хэлтсийн дарга, Хяналтын улсын байцаагч нартай хамтран шалгасан.
5. Улсын бүртгэлийн нэгдсэн архивын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 10/801 тоот албан бичгээр ирүүлсэн жагсаалтын дагуу 27 иргэний ИУБ-11, ИУБ-12, ИУБ-13, ИУБ-14, ИУБ-31 маягтуудыг Цахимжуулсан материал харах, ашиглах, засварлах програмд цахимжуулсан.
6. Гурвантэс, Цогтцэций, Ханхонгор, Ханбогд сумдын улсын бүртгэгч нар сумандаа ЭХЭУБүртгэлийн үйлчилгээг иргэдэд хүргэж эхэлсэн бөгөөд дадлагажих зорилгоор хэлтэс дээр бүх сумдын улсын бүртгэгч нар 14 хоногийн хугацаанд ээлжилж ажилласан.

7. 2022.02.18-ны өдөр УБЕГазраас ирсэн чиглэл, ЭХЭУБүртгэл бүртгэж эхэлсэн сумдад чиглэл өгөх зорилгоор онлайн сургалт зохион байгуулсан.
8. Шилжин ирсэн иргэдийн хувийн хэрэг бусад аймгуудаас ирэхэд эхнэрийн хувийн хэрэгт ИУБ-15, ИУБ-16 ирж байсан тул Нэгдсэн архивт чиглэл авах тухай санал хүргүүлсний дагуу 2022.02.23-ны өдрийн 10/1536 тоот чиглэлийг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.
9. Хэлтсийн үйлчилгээний зааланд байрлуулсан КИОСК машин хэвийн үйл ажиллагаанд орж Иргэний улсын бүртгэлийн 12 төрлийн лавлагааг иргэдэд үнэ төлбөргүй олгож, иргэний үнэмлэх болон гадаад паспортын дахин олголтын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна.
10. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8-д заасны дагуу Даланзадгад, Номгон, Баян-Овоо, Булган сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль товлон зарласан тухай тогтоолуудыг програмд шивж оруулсан.
11. Иргэний улсын бүртгэлийн тасгийн архивт байрлах 46890 иргэний цаасан суурьт эх нотлох баримтыг Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан, Цахимжуулсан материал харах, ашиглах, засварлах програмд тус тус тулган шалгахад 19116 иргэний маягт-7 576, ХААТР-1 761, ХААТР-11 5035, ИУБ-12, ХААТР-12 130, ИУБ-13, ХААТР-13 728, ИУБ-14, ХААТР-14 222, ИУБ-15, ХААТР-15 1580, ИУБ-16, ХААТР-16 278, ИУБ-21, ХААТР-21 2324, ИУБ-31, ХААТР-31 17832 нийт 29466 ХААТР маягт цахимжаагүй байсныг нэгдсэн архивт хүргүүлсэн.
12. Улаанбаатар хотын хаягтай 1358 иргэний хувийн хэргийг Нийслэлийн улсын бүртгэлийн газарт, Найлах дүүрэг 17 иргэн, Багануур дүүрэг 16, Багахангай дүүрэг 3, Арханай аймаг 14, Баян-Өлгий аймаг 1, Баянхонгор аймаг 28, Булган аймаг 15, Говь-Алтай аймаг 2, Говьсүмбэр аймаг 17, Дархан-Уул аймаг 74, Дорноговь аймаг 62, Дорнод аймаг 14, Дундговь аймаг 87, Завхан аймаг 19, Орхон аймаг 86, Өвөрхангай аймаг 36, Сүхбаатар аймаг 3, Сэлэнгэ аймаг 61, Төв аймаг 7, Увс аймаг 5, Ховд аймаг 12, Хөвсгөл аймаг 21, Хэнтий аймаг 4 нийт 1962 иргэний хувийн хэргийг харъяалалын дагуу хүргүүлсэн.
13. Нийт 845 иргэний гэрлэлт, гэрлэлт цуцлалт /ХААТР-15, ИУБ-15, ХААТР-16, ИУБ-16/-ын ХААТР маягтыг нөхрийн харъяалалын дагуу хүргүүлсэн.

14. Нас барсан 614 иргэний гэрлэлт, гэрлэлт цуцлалт /ХААТР-15, ИУБ-15, ХААТР-16, ИУБ-16/-ын ХААТР маягт, 53 иргэний хувийн хэргийг гаргаж нас барсан иргэдийн хувийн хэрэгт он цагийн дараалаар байршуулсан.
15. Хувийн хэргээс гаргасан ХААТР-22 23331, ХААТР-23 3564, ХААТР-24 3238, иргэний үнэмлэх олгосон хуудас /ИУБ-21/ 141 ХААТР маягтыг жагсаалт гарган баримт бичиг нягтлан шалгах комиссоор оруулахаар бэлтгэсэн.
16. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх, эдгээртэй холбоотой гомдлыг шийдвэрлэх ажлын хүрээнд Өмнөговь аймгийн 5 сумын 5 багийн 5 хэсгийн 3739 сонгогчийн хэсэг оноолтыг <http://192.168.154.143> Иргэний улсын бүртгэлийн системд нягтлан шалгаж илтгэх хуудсыг хүргүүлэн ажилласан.
17. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” А/284 тоот тушаал, Монгол улсын сонгуулийн ерөнхий хорооны 2022 оны 02 дугаар сарын 11 ны өдрийн 1/29 тоот албан бичгийг хэрэгжүүлж ажилласан.
18. 2022 оны 04 дүгээр сарын 28-29 ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Манлай суманд улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэн үндэсний энгийн гадаад паспортын 30 бүртгэл, дахин олголтын 8 бүртгэл авч 43 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.
19. Улсын бүртгэлийн хэлтсээс 2021 оны 01 дүгээр сарын 01 нээс 2022 оны 04 дүгээр сарын 06 ны хооронд бүртгэгдсэн нийт 792 гадаад паспортын бүртгэлийг Иргэний улсын бүртгэлийн системд нягтлан шалгаж гадаад паспортын Е дугаар ороогүй 96 иргэний Е дугаарыг Иргэний улсын бүртгэлийн системд нөхөн оруулсан.
20. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт заасны дагуу сонгогчдын

нэрийн жагсаалтад хийгдсэн нэмэлт тэмдэглэгээг нягтлан шалгаж илтгэх хуудсыг холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

21. 2022 оны 05 дугаар сарын 14 ны өдөр Даланзадгад сумын Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх “Хөдөлгөөнт баг” арга хэмжээнд оролцож 158 иргэн тоон гарын үсэг олгож 241 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.
22. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журмын 2.4 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 3 дугаар баг 14-1-4 дүгээр хэсэг, Баян-Овоо сумын 1 дүгээр баг 14-3-1 дүгээр хэсэг, Булган сумын 3 дугаар баг 14-4-3 дугаар хэсэг, Мандал-Овоо сумын 3 дугаар баг 14-6-3 дугаар хэсэг, Номгон сумын 1 дүгээр баг 14-9-1 дүгээр хэсгийн хорооны 3917 сонгогчийн хэсэг оноолтыг <http://192.168.154.143> Иргэний улсын бүртгэлийн системд нягтлан шалгаж илтгэх хуудсыг холбогдох газарт хүргүүлэн ажилласан.
23. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйл, 20.9 дэх хэсэгт заасны дагуу Өмнөговь аймгийн 5 багийн 5 хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулийн хэсгийн хороодод хүргэх ажлыг зохион байгуулж илтгэх хуудсыг холбогдох газарт хүргүүлэн ажилласан.
24. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны нөхөн сонгуулийн технологийн сургалт зохион байгуулж Даланзадгад сумын 3 дугаар баг 14-1-4 дүгээр хэсэг нийт 2412 сонгогч, үндсэн 2339 сонгогч, түр хасав төлөвтэй 73 сонгогч, Баян-Овоо сумын 1 дүгээр баг 14-3-1 дүгээр хэсэг нийт 381 сонгогч, үндсэн 378 сонгогч, түр хасав төлөвтэй 3 сонгогч, Булган сумын 3 дугаар баг 14-4-3 дугаар хэсэг нийт 320 сонгогч, үндсэн 320 сонгогч, Мандал-Овоо сумын 3 дугаар баг 14-6-3 дугаар хэсэг нийт 319 сонгогч, үндсэн 317 сонгогч, түр хасав төлөвтэй 2 сонгогч, Номгон сумын 1 дүгээр баг 14-9-1 дүгээр хэсэг нийт 491 сонгогч, үндсэн 491 сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим сангаас 3 хувь хэвлэж Улсын бүртгэлийн хэлтсийн даргын гарын үсэг, тэмдэгээр баталгаажуулсан илтгэх хуудсыг ИУБГазарт хүргүүлсэн.

25. 2022 оны 06 дугаар сарын 19 ны өдөр аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийг амжилттай зохион байгуулж илтгэх хуудсыг ИУБГазарт хүргүүлэн ажилласан.
26. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хугацаа нь дууссан боловч хүчинтэй төлөвтэй 1729 иргэний үнэмлэхийг хүчингүй болгож илтгэх хуудсыг ИУБГазарт хүргүүлэн шийдвэрлүүлсэн.
27. 2022 оны 06 дугаар сарын 25 ны өдөр аймгийн Засаг даргын тамгын газраас зохион байгуулсан төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх “Явуулын оффис” арга хэмжээнд оролцож 60 иргэнд тоон гарын үсэг олгож 135 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.
28. 2022 оны 08 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд “Энержи ресурс ХХК, Таван толгой ХХК-ний ажилчдад 58 гадаад паспортын бүртгэл, 580 иргэний тоон гарын үсгийг олгож нийт 646 бүртгэл хийсэн.
29. 2022.09.09 ны өдөр хил нэвтрэх үнэмлэхийн судалгаа, 2022.09.16 ны өдөр иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийн судалгааг тус тус хүргүүлсэн.
30. 2022.09.23 ны өдөр Улсын бүртгэлийн байгууллагаас энгийн гадаад паспорт түүнийг орлох бичиг баримтын бүртгэл хөтлөх журмын төсөлд санал хүгүүлсэн мөн Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шинэчлэн боловсруулах шаардлагатай “Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”, “Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг архивт хадгалах журам батлах тухай”, “Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн хаалттай мэдээлэлтэй танилцах, мэдээлэл өгөх журам”, “Иргэний улсын бүртгэл хөтлөх журам” тус тус санал хүргүүлэн ажилласан.
31. 2022.09.02-03 ны өдөр Ноён суманд нэг цэгийн үйлчилгээ зохион байгуулан нийт 270 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.
32. 2022.09.06-07 ны өдрүүдэд Цогтцэций суманд байрлах “Эрдэнэс таван толгой” ХХК-ний ажилчдад гадаад паспорт, иргэний үнэмлэх, тоон гарын үсэг олгох ажлыг хийж гүйцэтгэсэн.
33. Монгол улсын Цахим гарын үсгийн тухай хууль, Өмнөговь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Нутгийн хишиг” хөтөлбөрийн 108 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022 оны 09 дүгээр сарын

- 27-30 ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн нутаг дэвсгэрт байрлах Цагаан хад сууршлын бүсэд үйл ажиллагаа явуулдаг компаниудын жолооч нарт, “Оюу толгой” ГХОХХК-ний албан хаагчдад мөн 2022 оны 10 дугаар сарын 10-13 ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “МАК” ХХКомпани, “SGS” ХХКомпаний албан хаагчдад тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулсан.
34. “Улсын бүртгэлийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан 15 сумдын улсын бүртгэгч нарт сургалт, мэдээлэл өгч хэлэлцүүлэг зохион байгуулсан.
35. Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 82 жил, “Улсын бүртгэлийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчилан таниулах, байгууллага хамт олны хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Даланзадгад сумын 1-8 дугаар багын иргэдэд 2022 оны 11 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулан 370 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.
36. Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд хөдөөгийн 14 сумд болон Даланзадгад сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага дээр очин 2022 оны 11 дүгээр сарын 25 ны өдрийн байдлаар 22834 иргэнд тоон гарын үсэг олгож бүртгэсэн.

ХОЁР. ИРГЭНИЙ ГЭР БҮЛИЙН БҮРТГЭЛ,ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЛААР

Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд Улсын бүртгэлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журмуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Иргэний бүртгэлийн мэдээллийн санд баталгаажуулсан бүртгэлүүд. Үүнд :

1. Төрсний бүртгэл – 1243
2. Үрчилсний бүртгэл –31
3. Овог,эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл - 86
4. Эцэг /эх/ тогтоосны бүртгэл - 32
5. Гэрлэсний бүртгэл - 285
6. Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл - 83

7. Нас барсны бүртгэл - 343
8. Аймаг дотрох шилжилт хөдөлгөөн -4463
9. Бусад аймаг хотоос шилжин ирсэн – 1976 тус тус бүртгэгдсэн байна.

**2021 онд бүртгэгдсэн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийг
2022 онд бүртгэсэн бүртгэлтэй харьцуулсан
үзүүлэлт**

Он	ИУБ-11	ИУБ-15	ИУБ-16	ИУБ-12	ИУБ-13	ИУБ-14	ИУБ-18
2021 он	1574	227	53	14	50	19	335
2022 он	1243	285	83	31	86	32	343
Өсөлт бууралт	-331	+58	+30	+17	+36	+13	+8

**2021 онд бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг
2022 онд бүртгэсэн бүртгэлтэй харьцуулсан үзүүлэлт**

Он	Бусад аймаг хотоос шилжин ирсэн	Аймаг дотор шилжин ирсэн
2021 он	1090	2244
2022 он	1976	4463
Өсөлт бууралт	+886	+2219

ГУРАВ. ҮНДЭСНИЙ ЭНГИЙН ГАДААД ПАСПОРТ ОЛГОЛТЫН ТАЛААР

2022 оны 11 дүгээр сарын 25 ны өдрийн байдлаар 1069 иргэнээс шинээр гадаад паспорт олгох хүсэлтийг хүлээн авч, гадаадад зорчих эрхийн бүртгэлд бүртгэсэн.

2021 онд гадаад паспорт, хил орчмын нэг болон олон удаагийн үнэмлэх олголтын байдлыг 2022 онд олгосон олголтын байдалтай харьцуулсан үзүүлэлт

Он	Гадаад паспорт шинээр	Хил зорчих олон удаагийн үнэмлэх	Хил зорчих нэг удаагийн үнэмлэх
2021 он	587	0	0
2022 он	1069	0	0
Өсөлт бууралт	+482	0	0

ДӨРӨВ. ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ ОЛГОЛТ, АРХИВЫН САНГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЛААР

2022 оны 11 дүгээр сарын 25 ны өдрийн байдлаар нийт 2713 иргэний цахим үнэмлэх хүлээн авч харъяалах сумдын улсын бүртгэгч нарт хүргүүлсэн.

ТАВ. АРХИВААС ЛАВЛАГАА ОЛГОЛТ

Иргэний улсын бүртгэлийн архивын сангийн баяжилтанд орсон ИУБ маягтын тоон мэдээллийг сар бүр тогтмол гарган УБЕГазрын Нэгдсэн архивт хүргүүлсэн.

2022 оны 11 дүгээр сарын 25 ны өдрийн байдлаар Иргэн, албан байгууллага, хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2972 лавлагаа гаргаснаас иргэнд 2451, албан байгууллагад 239, албан хэрэгцээнд 282 лавлагааг тус тус олгож, ИУБ-11 1243, ИУБ-12 31, ИУБ-13 86, ИУБ-14 32, ИУБ-15 285, ИУБ-16 83, ИУБ-18 343, ИУБ-31 2713 нийт 4816 маягт архивт байрлуулж, архивийн баяжилтыг цаг тухайд нь бүрэн хийж ажилласан.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр давхардсан тоогоор 15588 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна.

3. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ.

Нэг. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааны бодлого төлөвлөлтийн хүрээнд

Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд Улсын бүртгэлийн хууль, журам болон холбогдох бусад хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг бүрэн хангаж, удирдлагаас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээдэд хуульд нийцүүлэн хөнгөн шуурхай үйлчлэх зорилго тавин ажиллаж байна.

УБЕГ-ын даргын 2021.12.24-ны өдрийн Б/701 тоот тушаалаар Ханбогд сум, Гурвантэс сум, Цогтцэций сумдын улсын бүртгэгч нарт, 2022.06.15-ны өдрийн Б/355 тоот тушаалаар Манлай сумын улсын бүртгэгчид ЭХЭУБүртгэлд бүртгэх эрх олгосоны дагуу 2 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд Гурвантэс, Цогтцэций сумдын улсын бүртгэгч нарыг УБХ-ийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд дадлагажуулж, 2022.11.25-ны өдрийн байдлаар Ханбогд сум 450 бүртгэл, Гурвантэс сум 218 бүртгэл, Цогтцэций сум 1116 бүртгэл, Манлай суманд 77 бүртгэл тус тус бүртгэж нийт 1861 бүртгэл бүртгэсэн байна.

2022.03.03-05-ны өдрүүдэд Ханбогд суманд ажиллан улсын бүртгэгчийг ЭХЭУБүртгэлд дадлагажуулж мөн Ханбогд сумын ЗДТГазартай хамтран ЭХЭУБүртгэлийн “Нэг цэгийн үйлчилгээ”-г зохион байгуулж шинээр ашиглалтанд орсон 207/1, 207/2 орон сууцны захиалагч нарын өмчлөх эрхтэй холбоотой бүртгэлийг хүлээн авч бүртгэн нийт 74 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

УБЕГ-ын даргын 2022.04.08-ны өдрийн А/244 тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу 200 хувийн хэрэгт дүн шинжилгээ хийж илтгэх хуудсыг ЭХЭУБ-н газарт хүргүүлэн 2022.04.29-ны өдрийн 6/3763 тоот чиглэлийн дагуу архивын цаасан суурьт нотлох баримтыг цахимжуулах ажлын явцад хувийн хэрэгт тусгаарласан 67.496 хуудас нотолгооны ач холбогдолгүй баримтыг хувийн хэргээс гаргаж ББНШК-ын шийдвэрээр устгалд оруулахаар аймгийн архивын газарт хүсэлт хүргүүлсэн.

ЭХЭУБүртгэлийн архивын ажлын төлөвлөгөөний дагуу ЭХЭУБ-ийн 21458 цаасан суурьт нотлох баримтыг цахим мэдээллийн санд нягтлан шалгаж алдаатай цахимжсан 101 хувийн хэрэгт хяналтын улсын байцаагчийн 1500 тоот дүгнэлтийн үндэслэн засвар өөрчлөлт хийж ЭХЭУБ-н газарт мэдээг хүргүүлсэн.

2022.04.27-29-н өдрүүдэд шиф байгууллага болох Манлай суманд Улсын бүртгэлийн нээлттэй өдөрлөг зохион байгуулж иргэдэд ЭХЭУБ-ийн мэдээлэл хүргэн, байгууллагуудын дунд гар бөмбөгийн тэмцээн, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад мэдээлэл хийж, Улсын бүртгэлийг хэн сайн мэдэх вэ сэдэвт АХА тэмцээн зохион байгуулж, ЭХЭУБүртгэлийн 65 материал хүлээн авч үйлчилсэн.

2022.05.14-ны өдөр Даланзадгад сумын ЗДТГазраас зохион байгуулсан “Төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх хөдөлгөөнт баг” арга хэмжээнд оролцож ЭХЭУБ-ийн чиглэлээр 75 материал хүлээн авч үйлчилсэн.

2022.05.25-н өдөр Цогтцэций сумын багуудын нэгдсэн өдөрлөг, арга хэмжээнд оролцон ЭХЭУБ-ын 46 материал хүлээн авч үйлчилсэн.

Улсын бүртгэлийн Ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд газар эзэмшиж, ашиглах эрхийн А, Э дугаар олгогдсон 628 бүртгэлийн хуудсыг хэвлэн авч архивласан.

Гурвантэс сумын ИТХ-ын 2021.04.23-ны өдрийн 21 тоот тогтоол, 2022.09.28-ны өдрийн А/183 тоот тогтоолуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2022.10.10-ны өдрөөс 10.14-ны өдрүүдэд Гурвантэс сумын ЗДТГазартай хамтран улсын бүртгэлийн үйлчилгээгээр 61 иргэнд үйлчилсэн.

Сумдын улсын бүртгэгч нараас ЭХЭУБ-ын анхны бүртгэлийн 78 бүртгэлийн мэдүүлэг хүлээн авч шалган 13 мэдүүлэг буцааж, 69 бичигдсэн гэрчилгээг бүртгэгч нарт хүргүүлэн иргэдийн гарт олгосон.

УБЕГЗазаас зохион байгуулсан онлайн сургалтанд 3 удаа хамрагдаж өгсөн чиглэл зөвлөмжийг өдөр тутмын ажил үйлчилгээнд мөрдөн ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн сарын мэдээг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газар, Архивын газарт тус тус хуулийн хугацаанд хүргүүлэн газар, хэлтсийн дарга, холбогдох албан тушаалтнуудыг эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажилласан.

Өмнөговь аймгийн Засаг даргын 2022.11.08-ны өдрийн А/597 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн удирдамжийн дагуу 2022.11.09-ны өдрөөс 11-ны өдрүүдэд Гурвантэс, Ноён сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 11 компани дээр ажиллан үл хөдлөх хөрөнгүүдтэй газар дээр нь танилцаж, ГХБХБ-ын газар, Татварын газартай тулган мэдээлэл солилцож нурааж буулгасан боловч бүртгэлд өөрчлөлт оруулаагүй, хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн, хэмжээ, үнэ зөрүүтэй зэрэг зөрчлийг арилгуулах санал, илтгэх хуудсыг ажлын хэсэгт хүргүүлэн ажилласан.

УБЕГ-ын ЭХЭУБ-ын газраас ирүүлсэн сумдын улсын бүртгэгч нарын бүртгэлийн судалгаа, 2022.11.08-ны өдрийн 6/9582 тоот Хугацаатай үүрэг өгөх тухай албан бичиг, хавсралтыг хүлээн авч барьцаалагчийн мэдээлэл алдаатай 19 бүртгэлийг засварлаж, үнэ ороогүй 4 бүртгэлийн мэдээллийг шалгаж илтгэх хуудас, жагсаалтын хамт ЭХЭУБ-ын газарт хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн Ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд газар эзэмшиж, ашиглах эрхийн А, Э дугаар олгогдсон 1395 бүртгэлийн хуудсыг хэвлэн авч архивласан.

Сумдын улсын бүртгэгч нараас ЭХЭУБ-ын анхны бүртгэлийн 95 бүртгэлийн мэдүүлэг хүлээн авч 149 бичигдсэн гэрчилгээг бүртгэгч нарт хүргүүлэн иргэдийн гарт олгосон.

УБЕГазраас зохион байгуулсан онлайн сургалтанд 5 удаа хамрагдаж өгсөн чиглэл зөвлөмжийг өдөр тутмын ажил үйлчилгээнд мөрдөн ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тоон мэдээг сар бүр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар, Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газарт тус тус хуулийн хугацаанд хүргүүлж сар бүр бүртгэлийн инфо мэдээ гарган газар, хэлтсийн дарга, холбогдох албан тушаалтнуудыг эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажилласан.

Хоёр. Эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг бүртгэж баталгаажуулах

2022 оны 11 дүгээр сарын 25 ны өдрийн байдлаар иргэн, хуулийн этгээдээс үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой бүртгэлийн мэдүүлэг **3591**, газар өмчлөх эрхтэй холбоотой бүртгэлийн мэдүүлэг **5881** нийт **9472** мэдүүлэг хүлээн авч хянан, холбогдох хууль тогтоомжийн дагуу эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.

Эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэлд 2540 иргэний өмчлөх эрхийг баталгаажуулсанаас : Төрөөс үнэгүй хувьчилсан газар өмчлөх эрхийн бүртгэл 1953, Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэл 395, шинээр баригдсан орон сууцны анхны бүртгэлд 184, төрөөс хувьчилсан орон сууцны өмчлөх эрхийг анх удаа бүртгүүлэх 8 хүсэлт хүлээн авч бүртгэсэн.

Гэрээ хэлцэл 5585 бүртгээгдсэнээс: Худалдах, худалдан авах гэрээ 1384, Бэлэглэх гэрээ 195, Арилжих гэрээ 40, Хамтран өмчлөгч өөрчлөгдөх 50, гэрээслэлээр болон өв залгамжлах эрхийн бүртгэл 131, Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл 3, эрх бүхий этгээдийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх 18, Барьцааны гэрээтэй холбоотой бүртгэл 3746, бусад гэрээ 18 тус тус бүртгэсэн.

Эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт залруулгаар 708 бүртгэл бүртгэсэнээс: Эд хөрөнгийн хаяг, хэмжээ, үнэ, гүйцэтгэл өөрчлөгдөх 541, Эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх, залруулга 4, үрэгдүүлсэн болон гэмтээсэн гэрчилгээ дахин олгох бүртгэл 104, хувийн хэрэг хаах бүртгэл 59 тус тус бүртгэсэн.

Гурав. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаарх мэдээллийн сан болон нотлох баримтаар хувийн хэрэг бүрдүүлж, иргэн, хуулийн этгээд болон хууль хяналтын байгууллагыг лавлагаа, мэдээллээр хангах

Шүүх, Цагдаа, Прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба болон бусад байгууллагад албан бичгээр эд хөрөнгө өмчлөх эрхтэй холбоотой 266 лавлагаа олгосон бөгөөд эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр 126 үл хөдлөх хөрөнгөд тусгай тэмдэглэл бүртгэж, 100 хөрөнгийн тусгай тэмдэглэл хүчингүй болгосон. Байгууллагыг төлөөлж эд хөрөнгийн маргаантай бүртгэлээр шүүх хуралд оролцоогүй. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар иргэн, хуулийн этгээдэд 373 лавлагаа олгосон.

Иргэн, хуулийн этгээдээс хүлээн авсан эх нотлох баримтуудаар хувийн хэрэг үүсгэж газар өмчлөх эрхийн **17838** хувийн хэрэг, газраас бусад үл хөдлөх хөрөнгийн **9210** хувийн хэрэг, газар эзэмших эрхийн **4486** хувийн хэрэг, газар ашиглах эрхийн **133** хувийн хэрэг нийт **31667** хувийн хэрэг цаасан хэлбэрээр архивт хадгалдагдаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний хураамжаар нийт **109,238,40** төгрөгийг улсын төсөвт, тэмдэгтийн хураамжаар **7,839,433** төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсаны орлого **495,776,305** төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

4. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ.

Тайлангийн хугацаанд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ажил, үйлчилгээг Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журам, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийг бүрэн хэрэгжүүлж, 2022 оны 11 дүгээр сарын 25 ны

өдрийэ байдлаар нийт 2893 иргэн, хуулийн этгээдэд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн. Үүнд:

- ✓ Хуулийн этгээд нэрийн баталгаажуулалт - **560**
- ✓ Шинээр үүсгэн байгуулсан хуулийн этгээд - **414**
 - Хязгаарлагдмал хариуцлагатай компани – 336
 - Төрийн бус байгууллага /НҮТББ, ГҮТББ/ – 55
 - Нөхөрлөл – 5
 - Хоршоо – 8
 - Төрийн байгууллага албан газар – 3
 - Сан – 5
 - Үйлдвэрчний эвлэлийн байгууллага - 1
 - Шашны байгууллага - 1
- Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт - **867**
- ✓ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгосон – **288**
- ✓ Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа олгосон -**114**
 - Цахим сүлжээнээс - 60
 - Архивын хуулбар – 5
 - Төрийн байгууллагад - 49
- ✓ Хуулийн этгээд татан буулгасан бүртгэл – **9** тус тус бүртгэсэн.
- ✓ Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.3 т заасаны дагуу Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулах **43** хуулийн этгээдийн салбарыг бүртгэсэн.
- ✓ Хуулийн этгээдийн хориг тавьсан -1, хориг цуцалсан 1 бүртгэл хийсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны а/216 тоот тушаалаар батлагдсан “Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”-ын дагуу Хуулийн этгээдтийн тамга, тэмдэгийн хяналтын хуудас **519** олгож, хуулийн этгээдийн **79** тамга, тэмдгийг хураан авч хүчингүй болгосон.

Тайлангийн хугацаанд шинээр байгуулагдсан, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн, лавлагааны эх нотлох баримт бичиг хураан авсан тамга тэмдгийг тус тус дүрэм журмын дагуу архивт хүлээлгэн өгч, цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна.

2022 оны 11 дүгээр сарын 25 ны өдрийн байдлаар хуулийн этгээдийн бүртгэлийн бүх төрлийн үйчилгээний хураамж **63252000** төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Хуулийн этгээдийн бүртгэлийн хөдөлгөөний тоон мэдээ, архивын мэдээ, үнэт цаасны мэдээ, үйлчилгээний орлогын мэдээг сар бүрийн 25 ны өдрөөр гаргаж УБЕГазрын хуулийн этгээдийн газар, архивын газар, хэлтсийн нягтлан бодогчид тус тус хүргүүлэн ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд дараах ажил, үйлчилгээг гүйцэтгэсэн. Үүнд:

Төрийн албаны салбар зөвлөлөөс 7 хоногийн 4 өдөр болгон зохион байгуулагддаг онлайн сургалтанд 19 удаа хамрагдсан.

2022 оны 04 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд Жижиг дунд үйлдвэрийн газар, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газартай хамтран зохион байгуулсан “Хоршооны шинэчилсэн бүртгэл зохион байгуулах арга хэмжээ” сэдэвт сургалтанд хамрагдсан.

2022.04.30 ны өдөр “Монгол бичиг үндэсний хөтөлбөр 3” хөтөлбөрийн хүрээнд “Хос бичигтэн- Өмнөговьчууд” аяны хүрээнд зохион байгуулагдсан монгол бичгээр уншиж, бичиж, компьютерт шивж сурах, цахим орчинд хэрэглэх чадвар нэмэгдүүлэх сургалтанд хамрагдсан.

2022.05.26, 2022.06.17 ны өдрүүдэд Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарт зориулсан онлайн сургалтанд хамрагдсан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 26 ны өдрийн 1/3681 тоот чиглэл хүргүүлсэн албан бичгийн дагуу хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүргүүлээгүй 630 хуулийн этгээдийн жагсаалт болон холбогдох утасны дугаарын жагсаалтийг мэдээллийн сангаас нягтлан шалгаад тус аймгийн 11 сумын улсын бүртгэгч болон хэлтсийн улсын бүртгэгч М.Түвшинжаргал, Б.Баясгалан, З.Хасар, ЭХЭУБТасгийн архивч А. Цэцэгжаргал нарт хуваарилан өгч тус бүртэй холбогдож бүртэл хийлгэх зөвлөгөө мэдээллийг хүргэснээр 99 хуулийн этгээд нөхөн бүртгэл хийлгэсэн байна.

Орон нутгийн өмчийн тооллогын ажлын хэсгийн үүрэг даалгаврын хүрээнд Өмнөговь аймгийн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зөрчил арилгах ажлыг зохион байгуулсан. Хуулийн этгээдийн улсын бүртгэлд ТБАГ,УТҮГ гэсэн хариуцлагын хэлбэртэй 182 хуулийн этгээдээс хуулийн этгээдийн улсын бүртгэлийн шинэчилсэн хуулийн дагуу 77 хуулийн этгээдийг ТБАГ хэлбэрээр, 97

хуулийн этгээдийг УТҮГ хэлбэрээр бүртгэж, бүртгэл хийлгээгүй 11 хуулийн этгээдэд бүртгүүлэх тухай албан бичиг хүргүүлэн ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 17 ны өдрийн 1/4327 тоот чиглэл хүргүүлсэн албан бичгийн дагуу хоршооны шинэчилсэн бүртгэлийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж хуулийн этгээдийн бүртгэлийн нэгдсэн сангаас шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэх хоршооны холбогдох мэдээллийг /хоршооны нэр, регистрийн дугаар, удирдан төлөөлөх хүн, утасны дугаар, хаяг/-ыг татан авч тус аймгийн сумын улсын бүртгэгч нарт хуваарилан өгч тус бүртэй холбогдож мэдээлэл хүргүүлэх, олон нийтийн сүлжээгээр мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. Өмнөговь аймгийн харьяалах засаг захиргааны нэгжид бүртгэлтэй нийт 103 хоршоо шинэчилсэн бүртгэлд бүртгүүлэхээс 46 хоршоо бүртгэлд хамрагдаж, 5 хоршоо татан буугдах хүсэлт гаргаж, 2 хоршоо татан буугдах бүртгэл хийлгэсэн байна.

2022 оны 04 дүгээр сарын 14 ны өдөр Өмнөговь аймгийн Даланзадгад сумаас зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн.

2022 оны 05 дугаар сарын 14 өдөр Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ЗДТГазраас зохион байгуулагдсан төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх “Хөдөлгөөнт баг” арга хэмжээнд оролцож хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг 25 иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн ажилласан.

2022 оны 08 сарын 17 ны өдөр аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан “Галын аюулгүй байдал” сэдэвт танхимын сургалт, 2022 оны 09 сарын 20 ны өдөр аймгийн Насан туршийн боловсролын газраас зохион байгуулсан “Амьдралаа гайхамшиг болгоё” сэдэвт танхимын сургалт, 2022 оны 09 сарын 29 ны өдөр аймгийн Насан туршийн боловсролын газраас зохион байгуулсан “Хүний харилцаа хандлага” сэдэвт танхимын сургалтанд тус тус хамрагдсан.

Тайлант хугацаанд УБЕГ-ын хүний нөөцийн програмд бие даах хичээлээс ерөнхий мэдлэгийн хичээл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 3 үе шат хичээл, Монгол бичгийн цахим хичээлүүдийг судалсан.

2022 оны 11 сарын 09 ны өдөр УБЕГ газрын ХЭУБГазраас ирүүлсэн хуулийн этгээдийн мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл зөрүүтэй 138 хуулийн этгээдийн мэдээллийг нэгдсэн сан болон архивын нотлох баримтад нягтлан шалгаж ажиллаж байна.

2022 оны 11 дүгээр сарын 18-нд Сумын улсын бүртгэгч нарт “Улсын бүртгэлийн үйл ажиллагаа”-ны талаар зохион байгуулсан сургалтанд мэдээлэл өгч ажилласан.

5. ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ТАЛААР

Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн Мэдээллийн технологийн ажилтан нь “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”, Монгол улсын Засгийн газраас баталсан “Мэдээлэл, сүлжээний аюулгүй байдлыг хангах” журмыг удирдлага болгон дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мэдээлэл технологийн чиглэлээр

Мэдээлэл технологийн чиглэлээр 2022 оны 11 дүгээр сарын 25ны өдрийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Иргэдэд үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт болон шинэчлэгдсэн баримт бичгүүдийг цахимд ойлгогдохуйц байдлаар байршуулсан.

Цахим хуудаст байгууллагын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг цаг тухай бүрт нь байршуулсан ба эхний хагас жилийн байдлаар цаг үе, үйл явдлын талаарх мэдээ 35, иргэд, аж ахуй нэгжүүдэд заавар зөвлөгөө өгсөн талаар бичлэг 10, иргэд аж ахуй нэгжүүдэд заавар зөвлөгөө өгсөн мэдээлэл 52-г байгууллагын албан ёсны цахим хуудас болох www.umnugovi.burtgel.gov.mn хаяг болон Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс facebook page-д байршуулан ажиллаж байна.

Ажлын сул орон тооны зарыг цахим хуудсанд байршуулан зарын групп хуудсанд нийтлэн олон нийтэд нээлттэй зарлан ажилласан.

Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар эцэслэн баталж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэглээнд нэвтрүүлэх болсон тул цахим гарын үсэг олгох програм хангамжийн бэлтгэл ажлыг хангах, бэлдэх ажлуудыг хийж гүйцэтгэхээр болсон билээ. Тус ажлын хүрээнд програм хангамжийн бэлтгэл ажлыг хангаж, иргэдэд цахим гарын үсэг олгох тухай сургалтыг зохион байгуулж, улсын бүртгэгч нарыг бүрэн хамруулсан.

Улсын бүртгэлийн хэлтсийн болон сумын улсын бүртгэгч нарын компьютер дээр шаардлагатай программуудыг суулгаж, иргэнд цахим гарын үсэг олгох ажлыг хуулинд заасан өдөр амжилттай эхлүүлсэн.

Улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээний зааланд байрлах КИОСК машинд image file уншуулан, иргэн цахим гарын үсгээ КИОСК машинаар авах бололцоог бүрдүүлэн ажилласан.

Байгууллагын ашиглах хугацаа дууссан эд хөрөнгө, компьютер болон бусад тоног төхөөрөмжүүдийг актлах санал гаргаж Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж шийдвэрлүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас хүргүүлсэн зөвлөмжийн дагуу цахим хуудсын ажиллагааг тогтворжуулж цаг үе, үйл явдлын мэдээг тухай бүрт нь байршуулж иргэдэд мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүргэх ажлыг хийж гүйцэтгэж байна.

Хэлтсийн албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмжүүдийг эвдрэл гэмтэл гарсан үед цаг алдалгүй тухай бүрт нь засварлаж хэвийн ажиллагааг хангасан.

Байгууллагын дотоод сүлжээний ажиллах хэвийн байдлыг бүрдүүлэн сүлжээнд алдаа гарах, тасрах гэх мэт техникийн саатлуудыг тухай бүрт нь холбогдох арга хэмжээг авч, 2022 онд Улсын бүртгэлийн ерөнхий газраас цахим видео хурал, болон сургалтууд 16 гаруй удаа хийгдэж цахим хурлыг тухай бүрт нь холбон техник төхөөрөмжийг хэвийн ажиллуулсан байна. Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь сумын улсын бүртгэгч нартайгаа цахим видео хурал болон сургалтыг 5 удаа холбон сургалтийг хэвийн зохион байгуулсан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн итгэмжлэгдсэн ажилчдад зориулсан хууль эрх зүй, арга зүйн сургалтыг цахим видео хэлбэрээр, “Ирц бүртгэлийн программын сургалт”-нд итгэмжлэгдсэн ажилчдад арга зүйн болон программын заавар зөвлөгөөг өгч ажилласан.

Байгууллагын сүлжээний аюулгүй байдал, гадны халдлага, мэдээлэл алдагдхаас урьдчилан сэргийлэн арга хэмжээ авч ажиллан Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн заавар зөвлөмжийн дагуу сүлжээний хамгаалалтыг сайжруулж тохиргоог тухай бүр хийж ажиллаж байна.

Ил тод байдлын чиглэлээр

Байгууллагын хийж гүйцэтгэсэн ажил, иргэдэд мэдээлэх шаардлагатай мэдээг цаг тухай бүрт нь байршуулсан ба 11 мэдээ, мэдээллийг хэлтсийн мэдээллийн самбарт байршуулсан.

Байгууллагын хийж гүйцэтгэсэн ажил, иргэдэд мэдээллэх шаардлагатай мэдээг цаг тухай бүрт нь байршуулсан ба цахим хуудас болон facebook хуудсанд 80 мэдээ тухай бүр мэдээллэсэн.

Өргөдөл, гомдол хүлээн авах хариуцсан албан хаагчийн албан тушаал, овог нэр, харилцах утасны дугаар тодорхой бичиж цахимд, Сул орон тооны зарыг нийтэд зарлах, цахим болон мэдээллийн самбарт нийт 7 сул орон тооны зарыг байршуулсан.

Бусад ажлын чиглэлээр

Байгууллагын эвдэрч засах шаардлагатай эд зүйлсийг тухай бүрт засаж янзалж хэвийн болгон янзалсан. Байгууллагын серверийн өрөөн доторх эд зүйлийг цэгцэлж хэрэггүй ашиглагдах боложгүй болсон эд зүйлсийг устгалд оруулсан.

Байгууллагаас зохион байгуулж байгаа хамт олны ажилд идэвх санаачлагатай оролцон, няравын ажил үүргийг давхар эрхэлж байгаа тул сар бүрийн үнэт цаасны мэдээг нэгтгэх, шаардлагатай үнэт цаасыг захиалах, бичиг хэргийн холбогдолтой зүйлсийг цуглуулах, зөв хувиарлах ажлуудыг тухай бүр шуурхай хийж, мөн удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг цаг тухай бүрт нь хийж гүйцэтгэж байна.

6. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР

Хяналтын улсын байцаагчаас Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журам болон бусад холбогдох хууль, журмыг сурталчилан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

Хяналт, шалгалтын ажлын төлөвлөгөөг улирал, хагас, бүтэн жилээр гарган хэлтсийн даргаар баталгаажуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна

Байнгын хяналтыг иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, архив, мэдээллийн технологийн аюулгүй байдлын чиглэлээр хийсэн.

Иргэний улсын бүртгэл: Зөрчлийн тухай хуулийн 15.24.1, 15.24.2, 15.24.4, 15.23.1.1. 10.20.1 дүгээр зүйлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг нийт

493 иргэн, хуулийн этгээдэд нийт 20 525 000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. Үүнээс:

- Иргэний үнэмлэх сунгалтын хугацаа хэтрүүлсэн 318 иргэнийг 6 360 000 төгрөгөөр,
- Иргэний цахим үнэмлэх үрэгдүүлсэн 153 иргэнийг 4 590 000 төгрөг,
- Иргэний цахим үнэмлэх гэмтээсэн 3 иргэнийг 75 000 төгрөг,
- Хуулийн этгээдийн тамга тэмдэгээ үрэгдүүлсэн 7 компанийг 3 500 000 төгрөгөөр,
- Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтөө хуулийн хугацаанд бүртгүүлээгүй 8 компанийг 4 000 000 төгрөгөөр тус тус торгож, тухай бүрт нь аймгийн Хяналтын прокурор Г.Ганбаярт хянуулж холбогдох зөвлөгөө мэдээллийг авч, хамтран ажилласан. Мөн шийтгэлийн хуудасны зарцуулалтын тайланг сар бүр гаргаж, ахлах нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн.

Иргэний баримт бичгийн зөрчлөө арилгуулах өргөдөл гаргасан 40 иргэний дүгнэлтийг Хяналт, шалгалтын газарт хүргүүлж, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд баталгаажиж бүрэн шийдвэрлэсэн. Хяналтын улсын байцаагчийн хяналт, шалгалтын төлөвлөгөөний дагуу хөдөөгийн 9 сумын 2021 онд бүртгэсэн иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлийн нийт 2565 материалд хяналт, шалгалт хийхэд ноцтой зөрчил дутагдал илрээгүй бөгөөд иргэний цахим үнэмлэхний хүчинтэй хугацааг нягтлан шалгах, өргөдлийн огноо, толгойг зөв бичүүлж байх тал дээр нийт бүртгэгч нарт 2022 оны 03 дугаар сарын 20-нд зөвлөмж хүргүүлсэн. Тайлант хугацаанд шилжилт хөдөлгөөний бүртгэл, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлийн бүрдүүлбэр материалын нийт 7414 бүртгэлд хяналт шалгалт хийхэд зөрчил дутагдал илрээгүй.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 7/3496 дугаар албан бичгээр ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу 15 сумын улсын бүртгэгч нарын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийг дуусталх хугацаанд бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний нийт 853 бүртгэлийн эх нотлох баримт болон ИУБ-22 маягтыг тулган шалгаж иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хуулийн хугацаанд үнэн

зөв шивж, баталгаажуулсанд хяналт тавиж, илтгэх хуудсыг Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.

Мөн Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч Г.Балжмаагийн гаргасан гомдлын дагуу Даланзадгад сумын 8 багийн 2022.04.25-2022.05.25-ны хооронд бүртгэгдсэн нийт 147 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн бүрдүүлбэр материалыг 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдөр нягтлан шалгаж Хяналт шалгалтын газарт илтгэх хуудсыг хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Улсын ерөнхий байцаагчийн 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр баталсан Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь хэлтсээс иргэний үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээг барьцаалж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хийх шалгалтын удирдамжийн хүрээнд холбогдох хяналт шалгалтыг бүрэн хийж илтгэх хуудсыг хүргүүлсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэл: Хуулийн этгээдийн оноосон нэрийн бүртгэл, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ERS програмд хандах эрхийн дагуу орж бүртгэлүүдийг өдөр тутам хянаж байна. Тайлангийн хугацаанд шинээр үүсгэн байгуулагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон нийт 498 бүртгэлийн бүрдүүлбэр материалын архивын хувийн хэрэг дэх эх нотлох баримтыг татан авч шалгахад зөрчил дутагдал илрээгүй, бүгд бүртгэлийн бүрдүүлбэр хангасан нотлох баримтууд байсан. Мөн хуулийн этгээдийн өмчийн тооллоготой холбоотойгоор хэлбэр болон хуулийн этгээдийн даргын өөрчлөлтийн, эцсийн өмчлөгчийн нийт 179 бүртгэлд байнгын хяналт тавиж, холбогдох зөвлөгөө мэдээллийг өгч ажилласан.

Хуулийн этгээдийн мэдээлэд оруулсан өөрчлөлтөө хуулийн хугацаанд бүртгүүлээгүй Зөрчлийн тухай хуулийн 15.23.1.1 дэх хэсэгт зааснаар торгуулийн арга хэмжээ авагдсан "Даланзадгад говийн ирээдүй"ОНӨААТҮГ, "ГЕГХГашуун сухайт дахь гаалийн газар"ТБАГУТҮГазар, "Долоон шар заг"ОНӨААТҮГазар, "Өм БОЭТөв", "Өм Гурвантэс сумын эрүүл мэндийн төв"ТБАГУТҮГазар, "Өм Гурвантэс сумын цэцэрлэг"ТБАГУТҮГазар, "Өм Гурвантэс сумын ЗДТГазар"ТБАГУТҮГазар, мөн хуулийн этгээдийн тамга тэмдгээ хаяж үрэгдүүлсэн "Мөнх говийн сүлд"ХХК, "Тэргүүн зээрд"ХХК, "Говь арслан"ХХК, "Эрдэнэсийн оргил"ХХК, "Галба ус"ХХК, "Цагаан овоо баялаг"ХХК-г зөрчлийн тухай хуулийн 10.20 дугаар зүйлийн 1 дэх

хэсэгт заасны дагуу 500 нэгжээр торгон, хуучин хяналтын дугаарыг хүчингүй болгосон дүгнэлтийг тус тус үйлдэж Хяналт шалгалтын газарт хүргүүлэн зөрчлийг бүрэн арилгасан.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл: ЭХЭУБүртгэлийн ePRS програмд хандах эрхийн дагуу орж бүртгэлийн бүрдүүлбэр материалуудыг түүвэрчлэн шалгаж байна. Тайлангийн хугацаанд газар өмчлөх эрхийн бүртгэл, барьцаат зээлийн гэрээ, БЗГэрээ дуусгавар болгосон, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэлийн нийт 2514 бүртгэлийн бүрдүүлбэр материалыг шалгахад ямар нэгэн зөрчил дутагдал илрээгүй. ЭХЭУБүртгэлийн эрх авсан Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумын улсын бүртгэгч нарын ирүүлсэн бүрдүүлбэр материалуудыг тухай бүр шалгаж, илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулан, холбогдох зөвлөгөөг өгч ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 59 дүгнэлтийг Хяналт шалгалтын газарт хүргүүлж, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд баталгаажиж бүрэн шийдвэрлэсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд заасан хяналтын үйл ажиллагаа болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын баталсан Хяналт шалгалтын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2 дах заалтад заасан “Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг улсын бүртгэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх” гэсэн ажлыг хэрэгжүүлж, улсын бүртгэлийг цахим хэлбэрээр хянаж, бүртгэл үнэн зөв байх зарчимд нийцүүлэх зорилгоор Өмнөговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэл, ЭХЭУБүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2022.10.01-2022.11.01-ний хооронд бүртгэгдсэн бүртгэлийн эх нотлох баримт улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд бүртгэгдсэн эсэхийг нягтлан шалгаж илтгэх хуудсыг хүргүүлсэн.

Иргэн, ЭХЭУБүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр иргэн, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтийн дагуу үйлдсэн нийт 108 дүгнэлтийг Хяналт шалгалтын зөрчлийн нэгдсэн санд бүрэн цахимжуулсан.

2022 оны жилийн эцсийн тайлан гаргасан

1. Ч.Энхмөнх - Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
2. Д.Наранбилэг - Хяналтын улсын байцаагч
3. С.Ариунсайхан - ИУБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч
4. Б.Азжаргал - ЭХЭБТасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч
5. З.Хасар - Иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч
6. Ч.Пүрэвдавга - Иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч
7. Т.Нямсамбуу - ЭХЭБТасгийн улсын бүртгэгч
8. М.Оюун-Эрдэнэ - ЭХЭБТасгийн улсын бүртгэгч.
- 9.М.Энхтогтох - Хуулийн этгээдийн улсын бүртгэгч
10. С.Батхүү - Ахлах нягтлан бодогч
11. А.Цэцэгдэлгэр - ИБТасгийн архивчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
12. А.Цэцэгжаргал - ЭХЭБТасгийн архивч
13. Б.Баясгалан - Даланзадгад сумын улсын бүртгэгч
14. О.Жижигчулуун - Архив, Бичиг хэргийн ажилтан
15. Сумын 11 улсын бүртгэгч